

## Түвшин: 1-2-р анги

### 3 онооны даалгавар:

1) Зурагт хэдэн амьтан байна вэ?



A) 3


B) 4

C) 5

D) 6

E) 7

2) Зургийн хоосон зайнд тохирох дүрсийг олоорой.



A)

B)

C)

D)

E)

3) Эдгээр амьтад нийтдээ хэдэн хөлтэй вэ?


A) 5

B) 10

C) 12

D) 14

E) 20



4) Ах “КЕНГУРУ” гэдэг үгийг хоёр удаа бичив. Тэгвэл У үсэг хэдийг бичих вэ?

A) 1

B) 2

C) 3

D) 4

E) 5

5) Эгч дөрвөн төрлийн наалддаг зураг ашиглан дараах зүй тогтлоор наажээ.



Тэр 10-р нүдэнд ямар зураг наах вэ?



A)

B)

C)

D)


E)

Хуудас 1

6) Дүү баасан гаригаас эхлэн “АВАРГА” гэдэг үгийг будаж эхэлжээ. Тэр өдөр бүр нэг л үсгийг буддаг бол хамгийн сүүлчийн үсгийг хэд дэхь өдөр будах вэ?


- A) даваа      B) мягмар      C) лхагва      D) пүрэв      E) баасан

7) Дараах зурааснуудаас аль нь хамгийн урт вэ?



- A) A      B) B      C) C      D) D      E) E

8) Мишээл нуурын эрэг дээр ус руу хараад зогсож байна. Тэр нууранд ямар дүрсийг харж байна вэ?




**4 онооны даалгавар:**

9) 13 хүүхэд нуугдаж тоглов. Нэг хүүхэд нь хайж байна. 9 хүүхдийг олсны дараа хэдэн хүүхэд олох вэ?

- A) 3      B) 4      C) 5      D) 9      E) 22

10) Ээж хэцэн дээр угаасан алчуур хатаажээ. Тэр аль боломжоороо цөөн хавчаар ашиглахыг хичээж байв. 3 алчуур хатаахад 4 ширхэг хавчаар хэрэглэв. Тэгвэл 9 алчуурыг хатаахад хэдэн хавчаар хэрэгтэй вэ?

- A) 9      B) 10      C) 12      D) 16      E) 18




11) Өнөөдөр Болд өөрийнхөө насан дээр эгчийнхээ насыг нэмэхэд нийлбэр нь 10 гарчээ. Нэг жилийн дараа тэр хоёрын насны нийлбэр хэд болох вэ?

- A) 5      B) 10      C) 11      D) 12      E) 20

12) Ганаагийн хичээл зурагт үзүүлсэн цагт тарав. Хичээл тарахаас 3 цагийн өмнө түүний ээж ирж уулзжээ. Тэр ээжтэйгээ хэдэн цагт уулзсан бэ?

- A) 1 цагт      B) 2 цагт      C) 5 цагт      D) 10 цагт      E) 11 цагт




Хуудас

13) Луу гурван толгойтой. Баатар лууны 1 толгойг цавчих бүрт шинээр 3 толгой гардаг. Баатар 1 толгойг цавчаад, дахин нэг толгойг цавчжээ. Тэгвэл одоо луу хэдэн толгойтой вэ?

- A) 7      B) 5      C) 6      D) 4      E) 8

14) Тоглоомын дөрвөлжин нүднүүдэд од, цэцэг, бэлэг, гацуур мод ээлжлэн байрлажээ. Тоглоомын хавтгай дээр жимсний шүүс асгарснаас болоод зарим зураг нь арилаад харагдахгүй болжээ. Шүүс асгарахаас өмнө нийт хэдэн ширхэг од байсан бэ?




- A) 3      B) 6      C) 8      D) 9      E) 20

15) Ах 12 чихэр, эгч 9 чихэр авчирч, харин дүү нь чихэр авчраагүй. Тэд авчирсан бүх чихрээ нийлүүлээд хүн бүрт тэнцүү хуваажээ. Тэд тус бүр хэдэн чихэр авах вэ?

- A) 3      B) 7      C) 8      D) 9      E) 12

16) Хадаа торгон дээр зурсан 9 ширхэг зургийг харж байв. Тэдгээр зурагны хамгийн зүүн талд нь луу, баруун талд нь эрвээхэй байна (Зураг харна уу).



Тэгвэл бар ба арслангийн зүүн талд, жимсний баруун талд ямар амьтан байна вэ?




5 онооны даалгавар:

17) Эмээ, өвөө хоёр 4 үзэг, ээж 6 бал авахад ижил хэмжээний мөнгө төлсөн ба нийт үнэ нь 24 дэвтэрний үнэтэй тэнцүү гэнэ. Тэгвэл 1 бал хэдэн дэвтэрний үнэтэй тэнцүү вэ?

- A) 2      B) 4      C) 6      D) 10      E) 12

18) Нэгэн болжмор хашаан дээр сууж байна. Тэр нэг үсрэхдээ зэрэгцээ хоёр хашааны мод хооронд л үсэрч чадна. Мөн нэг үсрэлтэнд 1 секунд зарцуулна. Болжмор 4 удаа урагшаа үсэрч 1 удаа хойшоо үсэрнэ, дахин 4 удаа урагшаа үсэрч 1 удаа хойшоо үсэрнэ гэх мэт үсэрч байв. Тэгвэл болжмор хашааны эхний модноос сүүлийн мод хүртэл хэдэн секунд зарцуулах вэ? (зураг хар)



- A) 10      B) 11      C) 12      D) 13      E) 14

19) Эмээ нь ач нартаа 11 ширхэг чихэр авчээ. Тэдгээрийн 5-д нь үзэм, мөн 7-д нь самар орсон гэнэ. Хамгийн багадаа хэдэн ширхэг чихэрт үзэм, самар хоёулаа орсон бэ?

- A) 1      B) 2      C) 5      D) 7      E) 12

20) Шинэ жилийн баяраар Амар, Болд, Вандан гурав тус бүр 10 ширхэг чихэртэй бэлэг авчээ. Хөвгүүд тус бүр 1 чихэр идэж, 1 чихэр багшдаа өгчээ. Тэд нийт хэдэн чихэртэй үлдсэн бэ?

- A) 8      B) 10      C) 24      D) 27      E) 30


21) Цэцэгний оронд ямар тоо байх вэ?

$$\begin{aligned} \bullet + \blacktriangle &= 3 \\ \blacktriangle + \blacktriangle &= 4 \\ \blacktriangle + \blacksquare &= 5 \\ \bullet + \blacksquare &= \text{flower} \end{aligned}$$

- A) 1      B) 2      C) 3      D) 4      E) 5

22) Өгсөн дөрвөн дүрснээс хэдийг нь  гэсэн хоёр дүрсэд хувааж болох вэ?

- A) 0      B) 1      C) 2  
D) 3      E) 4



23) Нэгэн том хайрцаг дотроо 3 хайрцагтай. Энэ 3 хайрцаг нь тус бүр 3 жижиг хайрцагтай бол нийт хэдэн ширхэг хайрцаг байна вэ?

- A) 9      B) 10      C) 12      D) 13      E) 15

24) Хөлөгт дараах даамнууд байрлажээ. Хөлгийн мөр ба багана бүрт 2 даам байхаар өөрчлөх хэрэгтэй. Үүний тулд хамгийн багадаа хэдэн даам авах вэ?

- A) 0      B) 1      C) 2      D) 3      E) 4

